



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/35

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн шалтгааны улмаас эмчлүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн Д.Ганбаатар, Г.Болд нарт тус бүр 500,000 (Таван зуун мянга) төгрөг, П.Цэрэндуламд 300,000 (Гурван зуун мянга) төгрөг, санхүүгийн дэмжлэг хүссэн “Сүүн тахилт” төрийн бус байгууллагаас архины хамааралтай иргэдэд сургалт зохион байгуулахад шаардлагатай 986.800 (Есөн зуун наян зургаан мянга найман зуу) төгрөг, Чингис хаан музейтэй хамтран аймгаа сурталчлах үйл ажиллагаанд оролцох 3 хүүхдэд нийт 1,500.000 (Нэг сая таван зуун мянга) төгрөг, Гавьяат багш С.Батсуурийн нэрэмжит “Цана -Тэшүүр”-ийн аймгийн аварга шалгаруулах тэмцээний арга хэмжээнд 1,000.000 (Нэг сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 4,786,800 (Дөрвөн сая долоон зуун наян зургаан мянга найман зуун мянган ) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712010106

Захирамж2024